



НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

2023 оныг хөдөлмөрийн сахилга бат,
ажлын хариуцлагыг сайжруулах жил
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, газрын дүрмийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, хүнд суртлыг бууруулах, төрийн албан хаагчдын ажлын бүтээмж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тус газар дээр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэн ажиллахыг Хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлагыг сайжруулах, албан тасалгаанд компьютер, техник хэрэгсэл дээр гадны иргэнийг суулгах болон ашиглуулах, байгууллагын бүртгэлтэй хөрөнгийг дур мэдэн өөр этгээдэд ашиглуулах, албан үүргийн дагуу олж мэдсэн мэдээ тайланг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглох, ажлын байранд чанга дуу чимээ гаргах, танхайрах, ажлын байр болон ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэх, ажлын байранд этгээд содон хэв маягийн чөлөөт загвараар хувцаслах, ажлын цагаар шалтгаангүйгээр ажлын байранд байхгүй байх зэрэг ёс зүйн зөрчлүүдийг гаргахгүй ажиллахыг хэлтсийн дарга нар, нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Нийслэлээс зарласан хурал, зөвлөгөөн, олон нийтийг хамарсан арга хэмжээнд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцрохгүй, таслахгүй байх, нийтээр тэмдэглэх баяр ёслол болон амралтын өдрүүдэд гар утсаа нээлттэй байлгаж, онцгой тохиолдолд ажиллахад бэлэн байхыг удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг ажилтан албан хаагчдад танилцуулж тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө батлуулж, зохион байгуулж ажиллах, шалгалтаар хийгдсэн ажлуудын талаар сар бүрийн эхний 7 хоногт даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг (Хяналт шинжилгээ, үнэлгээ хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Т.Энхмаад үүрэг болгосугай.

1150500000

5.Энэхүү тушаалыг зөрчсөн хэрэгжилтийг хангаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйл, Газрын дүрмийн 7.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 12 дахь хэсгүүдийг үндэслэн хариуцлага тооцож ажиллахыг газрын "Ёс зүйн зөвлөл" болон Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга О.Алтангэрэлд үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛД